



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/491

Булган сум


Соробан сампингийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчин Т.Хишигбуянгийн бэлтгэл сургуулилтын зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/026 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Америкийн нэгдсэн улсад 2026 оны 01 дүгээр сард зохион байгуулагдах “UAA-GLOBAL 2026” олон улсын соробан сампингийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцох болзлыг хангасан өсвөрийн тамирчин Т.Хишигбуянгийн бэлтгэл сургуулилтын зардалд 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР